



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/1459

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 45 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжилт хийгдэх БСШУСЯ/202003590 дугаартай Есөнбулаг сумын 4 дүгээр сургуулийн мэдээлэл зүйн лабораторийн кабинетын тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг "Ончсөрвей" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Есөнбулаг сумын 4 дүгээр сургууль (Ч.Сэндэрмаа)-д олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Есөнбулаг сумын 4 дүгээр сургууль (Ч.Сэндэрмаа)-д үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Т.Энхцэцэг), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн орон нутгийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ



C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001154